

**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХУУЛЬ,
ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН
/2021 оны 12-р сарын 08-ны өдрийн байдлаар/**

2021.12.08.

Багахангай дүүрэг

Хууль эрх зүйн сургалт, сурталчилгааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, шинэчлэн найруулагдсан болон шинээр мөрдөгдэж буй хууль, журамд нийцүүлэн үйл ажиллагааныхаа дүрэм, журмыг шинэчлэх, шинэлэг, бүтээлч ажил санаачлах, батлагдсан төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулах, ажилтан, албан хаагчдынхаа сахилга, хариуцлага, ажлын цаг ашиглалтыг сайжруулж, ажлын байранд архи, согтууруулах, ундаа хэрэглэхгүй байх талаар нутаг дэвсгэрийн нийт Аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга, эрхлэгч, захирал нарт үүрэг болгон, тайлангийн хугацаанд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

2021 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын хууль-36, Улсын Их Хурлын тогтоол-3, Ерөнхийлөгчийн зарлиг-4, Засгийн газрын тогтоол-32, Нийслэлийн Засаг даргын захирамж-44, Нийслэлийн Засаг даргын албан даалгавар-7, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэл-20 заалт буюу нийт 146 шийдвэрийн 178 заалтыг хяналтад авч хэрэгжүүлэн ажилласан.

Эдгээрээс бүрэн хэрэгжсэн 113, хэрэгжих шатанд 65, тасарсан заалт байхгүй бөгөөд жилийн эцсийн байдлаар шийдвэрлэлт 86.8%-тай байна. Дээд газрын тогтоол, шийдвэр болон дүүргийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд улирал бүр хяналт-шинжилгээ хийж, холбогдох тайланг гарган, НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлэн, monitoring.ub.gov.mn системд байршуулан хяналтын хуудас хөтлөн ажиллаж байна.

Нэг. Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн сан бүрдүүлэлт, бүртгэн цэгцлэх ажлын цахим гүйцэтгэл, цахим болон гар сангаас лавлагаа, мэдээлэл өгсөн байдал

Эрх зүйн сурталчилгааны самбар болон дүүргийн вэб сайт, байгууллагынхаа Хэвлэл мэдээлэл facebook цахим хуудсаар дамжуулан нийт 15 байгууллага 59 төрлийн 300 гаруй гарын авлага, зөвлөмжийг өгч ажилласан байна.

Иргэд, ААНБ, төрийн албан хаагчдад гар болон цахим сангаас Хууль, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, яамдын сайдын тушаал, нийслэл, дүүргийн ИТХ-ын тогтоол, Төрийн албаны зөвлөлийн тогтоол, журам, Нийслэл, дүүргийн Засаг даргын захирамж, нийслэл, дүүргийн онцгой комиссын даргын тушаалыг хувилан өгч, давхардсан тоогоор 46 иргэн, 22 байгууллагад лавлагаа олгоод байна. Мөн 33 иргэн эрх зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээлэл цахим болон утсаар авсан бөгөөд хүүхэд үрчлэн авах 5 иргэн, асран хамгаалагч харгалзан дэмжигчээр тогтоолгох 4 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, Цагдаагийн хэлтэс, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсээр дүгнэлт гаргуулан хувийн хэрэг бүрдүүлж ажилласан.

Эрх зүйн сурталчилгааны самбар болон дүүргийн вэб сайт, байгууллагын Хэвлэл мэдээлэл facebook цахим хуудсаар шинэчлэн гарсан хууль, тогтоомжийг тухай бүр байршуулж байна.

Дүүргийн Засаг даргын шилэн дансанд 162, тушаал 75, дүүргийн вэб сайтад 124 захирамжийг тус тус байршуулаад байна.

**Хоёр. Дүүргийн Засаг даргын захирамжийн хууль, эрх зүйн үндэслэлийг хянаж
санал дүгнэлт өгөх, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг
зохих журмын дагуу хууль зүйн асуудал хариуцсан төрийн
захиргааны төв байгууллагад хянуулж, бүртгүүлэх**

“Ахмадын хороо, Улаан загалмайн хороо, Багахангай тохижилт ОНӨААТҮГ, Илч-Орд ОНӨААТҮГ, Улаан загалмайн хороотой Хамтран ажиллах гэрээг хянаж, бүртгэлийн дугаар олгов. Хууль зүйн үндэслэлтэй, эрх зүйн хүчин чадал бүхий захирамж гаргах ажлын хүрээнд холбогдох хууль тогтоомж, эрх зүйн бусад актууд, www.legalinfo.mn сайтыг тогтмол ашиглан,

дүүргийн Засаг даргын А/220, Б/20 захирамжийг хянаж, дугаар олгосон байна. Эдгээр захирамжийг төрлөөр нь авч үзвэл: хүний нөөцтэй холбоотой-8, газрын харилцааны талаар-37, хөрөнгө санхүү болон үнэлгээний хороо байгуулах тухай-162, асран хамгаалагч харгалзан дэмжигч тогтоох-4, үрчлэлт 3, бусад чиглэлээр-43 захирамж батлагдан гарсан байна.

Тус хугацаанд дүүргийн Засаг даргын 16 захирамжийг хүчингүй болгож, тэмдэг, тэмдэглэгээг хийсэн бөгөөд бүхэлдээ хүчингүй болсон 6, хэсэгчлэн хүчингүй болсон 2 байна. Үүнд:

- Д. Төмөрхүүгийн газар эзэмших эрхийг дуусгавар болнох тухай
- Дүүргийн Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай
- Захирамж хүчингүй болгох тухай
- Гамшигаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай
- Гамшигаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлыг зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай
- Хамран сургах тойргийг шинэчлэн тогтоох санал боловсруулах Ажлыг хэсэг томилох тухай
- Захирамжид өөрчлөлт оруулах тухай
- ААНБ-ын газар эзэмших эрхийг дуусгавар болгох тухай
- Нэр өөрчлөх тухай

Дүүргийн Засаг даргын захирамжаар батлагдсан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэр гараагүй учир ХЗДХЯ-д бүртгэгдээгүй байна.

Гурав. Дүүргийн Засаг даргын шийдвэр хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар авсан арга хэмжээ

Тайлангийн хугацаанд Нутгийн захирагааны байгууллагаас гаргаж буй захирагааны актууд нь хуульд нийцсэн, хүний эрх зөрчөөгүй, хууль зүйн үндэслэлтэй гаргахад анхаарч, хяналт тавьж ажиллан, зөрчилтэй 6 захирамжийн зөрчлийг холбогдох хэлтсээр дамжуулан арилгуулж ажиллав.

Тус хугацаанд дүүргийн Засаг даргын А-220, Б-20, Байгууллагын даргын А-24, Б-80 тушаалын эрх зүйн үндэслэлийг хянаж, хууль, тогтоомжид нийцүүлэн гаргаж, бүртгэн дугаар олгож, цахим сан үүсгэн ажиллаж байна.

Дөрөв. Нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулсан эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын чанар, үр дүн, сургалт, сурталчилгааны чиглэлээр гаргасан гарын авлага, материал, шинээр боловсруулж буй хууль тогтоомжийн төслийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулах, санал авах

Монгол Улсын хэмжээнд коронавирус /КОВИД-19/ цар тахал өвчин гарч, Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан төлөвлөгдсөн сургалтууд цуцлагдаж, Дүүргийн хэмжээнд хууль, эрх зүйн цахим сургалтыг 46, танхимын сургалтыг 7 удаа зохион байгуулснаас ЗДТГ-аас холбогдох байгууллагуудтай хамтран 17, ААНБ-29, давхардсан тоогоор 250 гаруй иргэнийг хамруулж, нийт 59 төрлийн 300 гаруй гарын авлага, зөвлөмжийг өгч ажилласан байна. Үүнээс 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөх Монгол Улсын Засаг захирагаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар сургалт зохион байгуулав.

Шинэчилсэн найруулж байгаа 7 хууль, 8 журмын төсөлд иргэдээс гарсан 42 саналыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн. Мөн 38 иргэн эрх зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээлэл авсан байна. Эрх зүйн сурталчилгааны самбар болон дүүргийн вэб сайт, байгууллагынхаа Хэвлэл мэдээлэл facebook цахим хуудсаар дамжуулан 15 байгууллага 80 гаруй хууль, тогтоомжийг байршуулж ажилласан байна.

Тус дүүргийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны төлөвлөгөөг 2 бүлэг 20 заалттай боловсруулан, дүүргийн Засаг даргын 2021 оны А/38 дугаар захирамжаар баталгаажуулан хэрэгжилтийг ханган ажиллаж, төлөвлөгөөний биелэлт 80.4%-тай хэрэгжих байна.

Мөн Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга номыг 15 байгууллагын 50 албан хаагчид олгов.

Хууль, журмын төслийг дүүргийн вэб сайт, мэдээллийн самбар, facebook хуудсаар дамжуулан иргэдэд мэдээллийг тухай бүр хүргэн ажиллаж байна.

Хуулийн салбарын Нээлттэй хаалганы өдөрлөг: Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулагдаагүй боловч нийслэлийн хэмжээнд цахимаар зохион байгуулсаны дагуу 2 удаа мэдээ мэдээллийг Хороод, дүүргийн вэб сайт, хэвлэл мэдээллийн групп болон faceeet дамжуулан иргэдэд хүргэсэн. Тус цахим өдөрлөгөөр дүүргийн 5 иргэн мэдээ, мэдээлэл авсан байна.

БХД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүх хуралдааныг Иргэний танхимд 2 удаа зохион байгуулсан. 2021.12.03-ны өдрийн байдлаар нийт 69 хэргийн нэхэмжлэл хүлээн авсан үүнээс нэгтгэсэн хэрэг 1, шийдвэрлэсэн 46, нэхэсжлэлийг хүлээн авахаас татгалзсан 4, шилжүүлсэн 4, захирамж тогтоолоор хэргийг хэрэгсэхгүй болгосон 6, үлдэгдэл 7, түдгэлзүүлсэн 1 хэрэг байна. Мөн 69 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн байна.

Орон нутгийн зүгээс санаачлан “Эрүүл орчин–Иргэдийн сайн сайхан” III шатны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байгаа бөгөөд арга хэмжээний төлөвлөгөөг 4 бүлэг 20 заалттайгаар боловсруулан Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны А/06 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын 2021 оны А/28 дугаар захирамжаар 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулав. ЗДТГ, Цагдаагийн хэлтэс, ГБХЗХХ, Хороодын ажлын албанаас хамтран 2021 оны 03 сарын 30, 04 дүгээр сарын 01-ний өдрүүдэд Алтгана, Үнэтгэй, Бор үзүүр, Цайдам, Замчин Нуурын гэр хорооллын орчимд хяналт шалгалт зохион байгууллаа. Байнга архи согтууруулах ундаа хэрэглэдэг, архидалт зохион байгуулдаг 16 айл өрхөөр орж нөхцөл байдалтай танилцав. Шалгалтын явцад архи согтууруулах ундаа хэрэглэсэн 1 иргэнд анхааруулга, сээрэмжлүүлэг өгч, хүсэлт гаргасан 2 иргэний саналыг холбогдох албан тушаалтан, байгууллагад уламжлав.

**Тав. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион
байгуулсан ажил, үр дүн**

2021 оны эхний 11 сарын байдлаар албан байгууллага аж ахуйн нэгж иргэдээс зөрчлийн шинжтэй 281, гэмт хэргийн шинжтэй 61, нийт 342 гомдол, мэдээллийг хүлээн авч хуулийн хугацаанд шалган шийдвэрлэсэн байна. Гэмт хэргийн шинжтэй 61 гомдол мэдээлэл хүлээн авч хуулийн хугацаанд шалгаж ажилласанаар 19 гэмт хэрэг бүртгэгдсэн байгаа нь өмнө оны мөн үетэй харьцуулахад 13 нэгжээр буюу 1,3 дахин буурсан үзүүлэлттэй байна.

Зөрчлийн шинжтэй 281 гомдол мэдээллийг хүлээн авч шалгаснаас материалд зөрчлийн хэрэг нээж, 109 гомдол мэдээллийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, 25 гомдол мэдээллийг зөрчлийн шинжгүй үндэслэлээр татгалзаж шийдвэрлэсэн байна. Шүүхээр баривчилсан иргэн 14, шүүхээр торгуулсан иргэн 8, 59 иргэнийг 4.415.000 төгрөгөөр торгосон байна.

2021 оны эхний 12 сарын 05-ны байдлаар эрүүлжүүлэх байранд 165 иргэнийг хүлээн авч 684750 төгрөгийн төлбөрийг ногдуулаад байна.

Зөрчлийн тухай хуулийн дагуу 2021 оны 12 дугаар сарын 05-ны байдлаар 10590 иргэнд 344,474,310 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан байгаа нь өмнө оны мөн үетэй харьцуулахад иргэний тоо нь 296 нэгжээр буюу 2,8 хувиар өссөн, торгуулийн хэмжээ нь 12,9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Мөн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй этгээдүүд, хууль бусаар алт олборлогч, хууль бусаар ан агнаж болзошгүй, гэмт хэрэг зөрчилд холбогдож болзошгүй 45 иргэний бүртгэл судалгааг шинэчлэн гаргаж хяналт тавьж ажилласан.

Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр:

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудыг аттестатчилах тухай” А/141 дүгээр тушаалаар батлагдсан ажлын хэсэг удирдамжийн дагуу 2021 оны байдлаар согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж буй 5 аж ахуйн нэгжид аттестатчилал явуулав.

УБЗАА, НМХГ-аас гаргасан “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 02-02/72 дугаар мэдэгдлийг нийт 24 ААНБ, иргэнд хүргүүлж хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан. Нийт 45 зөрчил илэрч 37 зөрчлийг арилгуулж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.

Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй 7 хүнсний дэлгүүр ажиллах цагийн хуваарийг 07:00-22:00 цаг хүртэл тогтоож ажиллахад хяналт тавин ажилласан.

Энэ хугацаанд 18 градусаас дээш спиртын агууламж бүхий согтууруулах ундаагаар үйлчилсэн худалдааны байгууллага байхгүй байсан.

2021.03.17-2021.03.20-ны хооронд Хязгаарлалтын дэглэм тогтоосон 2-р хорооны 7 хүнсний дэлгүүрт дүүргийн Засаг даргийн А/37 дугаар захирамжийг хүргүүлэн танилцуулж гарын үсэг зуруулан баталгаажуулсан. Мөн архи согтууруулах унааны тусгай зөвшөөрөлтэй 4 ААНБ-ын 1304 ш архи, 887 ш пиво-г тоолон цагдаагийн хэлтэстэй хамтран лац тавьж ажилласан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Нийслэлийн Засаг даргын А/431 дүгээр захирамжийн хүрээнд 2021.06.07-ны өдөр Дүүргийн архи согтууруулах унааны тусгай зөвшөөрөлтэй 7 ААНБ-ын 1408 ш архи, 1130 ш пиво-г тоолон цагдаагийн хэлтэстэй хамтран лац тавьж ажилласан.

Дүүргийн худалдаа, үйлчилгээний газруудын “Коронавируст халдварт (Ковид-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”, тусгай нөхцөл шаардлага, цагийн хязгаар, “хариуцлагын гэрээ”-ний хэрэгжилтэнд хяналт шалгалтыг тавьж ажилласлаа. Шалгалтанд давхардсан тоогоор худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний 118 аж ахуйн нэгж, байгууллага, иргэн хамрагдсан. Үүнээс: -Хоол үйлдвэрлэл-25 -Бүх шатны боловсролын байгууллагууд-8 -Бусад /худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээ/-85 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдсан байна. Хяналт шалгалтаар илэрсэн 48 зөрчил дутагдлыг 96%-г нь богино хугацаанд арилгуулж, давхардсан тоогоор шалгалтад хамрагдсан 118 обьектын 189 ажилтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласлаа.

Монгол Улсын Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7.2 дугаар зүйлд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй газруудын хориглох зүйлд “21 наасанд хүрээгүй, эсхүл согтуу хүнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно” гэх заалтуудын хэрэгжилтийг хангаж ажилласан.

Сар бүрийн 01-ний өдрийн 00:00 цагаас 02-ны өдрийн 00:00 цаг хүртэлх хугацаанд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхгүй байх талаар хяналт тавьж ажилласан.

Захирамжийн хүрээнд дүүргийн 1,2 хорооны нутаг дэвсгэрт байрлах архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг 11 аж ахуй нэгж, байгууллагад Захирамжийг хэрэгжүүлж ажиллах талаар шаардлага-10, Цахим орчимд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 82, зурагт хуудас-250 бэлтгэж хүргүүлж, биелэлтийн хугацаанд хяналт тавьж ажиллаж байна.

Хууль тогтоомж тайлбарлан таниулах, ухуулга сурталчилгаа хийх, хүүхэд, залуучууд болон иргэд олон нийтэд зэрэгээр нөлөөлөх ажлыг өрнүүлэх зорилгоор дүүргийн 1, 2-р хороодын гэр бүлийн хүрээнд архидан согтуурч, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй 22 үүнээс хүүхдийн эрх зөрчиж болзошгүй 8 этгээдэд нэг бүрчилсэн хяналтыг тогтоож судалгаанд авж тэдгээрийг өдөр бүр эргүүлийн чиглэлд хамруулан ар гэртээ удаа дараа архидалт зохион байгуулж гэр бүлийн бусад гишүүдийн эрх ашиг сонирхлыг зөрчиж, хүүхдээ үл хайхарч, дарамт хүчирхийлэлд оруулж байж болзошгүй болон гэрээсээ гарах боломжгүй эрүүл мэндийн шалтгаанаар гэртээ асаргаанд байдаг, хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настнууд зэрэг нийт 10 айл өрхөөр орж тэдний санал хүсэлтийг сонсож, хууль тогтоомж тайлбарлан танилцуулж, яриа ухуулга хийсэн. Монгол Улсын Архидан согтуурахтай тэмцэх

тухай хуулийн 7.2 дугаар зүйлд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй газруудын хориглох зүйлд “21 насанд хүрээгүй, эсхүл согтуу хүнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно” гэх заалтуудын хэрэгжилтийг хангаж ажилласан.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр:

Замын цагдаагийн хэсгээс тайлант хугацаанд тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гудамж замын хөдөлгөөнд тавих хяналт зохицуулалтыг эрчимжүүлэх, хөдөлгөөнд оролцогчдын сахилга, соёлыг дээшлүүлэх чиглэлээр гудамж замын хяналт шалгалтаар нийт 304516 тээврийн хэрэгсэл шалгаж 10465 зөрчил илрүүлж, зөрчилтэй явсан 10465 жолоочид Зөрчлийн тухай хуулийг баримтлан 334,263,810 төгрөгийн торгууль ногдуулан, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 73 хүнийг илрүүлэн Зөрчлийн тухай хуулийн 14.7.3.1 дэх хэсэгт зааснаар 1 жилийн хугацаагаар эрхийг хасаж, 29,200,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 19-н иргэнийг Зөрчлийн тухай хуулийн 14.7.1 дэх хэсэгт зааснаар Шийтгэлийн хуудас /маягт 1,2,4/-р 3,800,000 төгрөгний торгууль ноогдуулж, жолоодох эрхгүй үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэж тээврийн хэрэгсэл жолоодсон 16 хүнийг Налайх, Багахангай дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр оруулан шүүгчийн шийтгэврээр 7-30 хоногийн хугацаагаар ШШГЕГ-н харьяа Баривчлах төвд хүлээлгэн өгч, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн хүнд тээврийн хэрэгслийн жолоогоо шилжүүлсэн 5 иргэний ЗТХ-н 14.7.4-т зааснаар 500,000 төгрөгийн торгууль ногдуулсан. ASAP сангаар эрэн сурвалжлагдсан 13 хүнийг олж тогтоосон, Налайх, Говьсүмбэр, Дорноговь аймгаас зарлагдсан 3 тээврийн хэрэгслийг, мал малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн тээвэрлэн явсан 11 тээврийн хэрэгслийг saatuuulan холбогдох албан тушаалтнуудад шилжүүлэн өгч ажилласан байна.

Дүүргийн нутаг дэвсгэрт гудамж замын 217 ширхэг гэрэлтүүлэгт сард 2 удаа үзлэг шалгалт хийж илэрсэн зөрчлийг Багахангай дүүргийн Хот тохижилтын албаар засварлуулж ажилласнаар замын гэрэлтүүлэг 90 хувьтай асаж байна.

Дүүргийн нутаг дэвсгэр болон Улсын чанартай А0101 авто замын эвдрэл гэмтлийн судалгааг гарган дүүргийн хот тохижилтын алба болон Налайх дүүргийн АЗЗАН ХК-нд хүргүүлэн нөхүүлэх ажлыг зохион байгуулж замын хэвтээ тэмдэглэгээг шинэчилж ажилласан байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхэд хамгааллын тухай хууль, тогтоомжийг сурталчлах ажлын хүрээнд

Багахангай дүүргийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны 2021 оны анхдугаар хуралдааныг 7 гишүүн буюу 60 хувийн ирцтэйгээр зохион байгуулж, 2020 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг танилцуулан 2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж гишүүдээс гарсан саналыг тусган батлууллаа.

Бэлгийн хүчирхийллийн хохирогч 14 настай 1 эмэгтэй хүүхдэд хорооны ажлын албаны зүгээс хууль тогтоомжид заасны дагуу үйлчилгээ үзүүлж, хяналтад авч ажиллаж байна.

“Хүүхэд хамгаалал” I нэгдсэн арга хэмжээний хүрээнд хараа хяналт сул 1 хүүхдийг илрүүлэн хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлж ажиллав. Мөн уралдаанч 23 хүүхэд, туслах уяач 1 хүүхдийг илрүүлж бүртгэн уяач зээдэд зөвлөгөө өгч ажиллалаа.

“Хүүхэд хамгаалал” 2 дугаар улирлын нэгдсэн арга хэмжээг батлагдсан удирдамжид заагдсан маршрутын дагуу 2021.06.03-ны өдрөөс дүүргийн нутаг дэвсгэр дэх үйлдвэрлэлийн бүс, төмөр замын өртөө, зөрлөгөөр хяналт шалгалт хийхэд хөдөлмөр эрхлэгч, хараа хяналт сул хүүхэд илрээгүй байна. Хараа хяналт сул 1 эрэгтэй, 1 эмэгтэй, үл хайхрах хүчирхийллийн хохирогч 1 эмэгтэй, бэлгийн хүчирхийллийн хохирогч 1 эмэгтэй хүүхдийг түр хамгаалах байранд хүлээн авч хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэн ар гэрт нь эргэн нэгтгэсэн ба үйлчилгээ, хяналт үргэлжилж байна. Хүүхдийг осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлж 84 удаагийн мэдээ мэдээлэл, шторкийг мэдээллийн бүхий л сувгаар дамжуулан иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулж байна.

Иргэн бүрийн баримтлах 10 зөв дадлыг сурталчлах, нөлөөлөх, хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Нийслэлийн залуучуудын баримтлах 10 зөв дадал” “Хотын соёл” аяныг хамтатган зохион байгуулав. Аянд 1259 иргэн нэгдсэн. Залуучуудын идэвх оролцоог нэмэгдүүлэх, байгууллагуудын ЗХЗ-ийн дарга, гишүүдийг урамшуулах, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “Эртэч залуучууд” өглөөлөг, “Эрт босвол нэгийг бүтээнэ” 3 сарын чөлөө, “Номын гайхамшиг” хэлэлцүүлэг, “Өглөөний бүжиг”, “Гэртээ хийж болох өглөөний дасгал хөдөлгөөн” сэдэвт цахим сургалтыг зохион байгуулж, 800 гаруй залуучууд хамрагдav.

Амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх модул сургалтуудыг цахимаар бичлэг болгон оруулж, нийт 560 хүний хандалт авсан. Зүүмээр 6 удаагийн сургалт зохион байгуулан 85 залуу хамрагдсан.

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий “Илрүүлэлт 2021” нэгдсэн арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран улирал тутам зохион байгуулж, уралдаанч, туслах уяач хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч, уяачдад хууль эрх зүй, хүүхдийн хүмүүжлийн арга, хүүхдийн эрхийг зөрчихгүй байх, аюулгүй байдалд анхаарах талаар зөвлөгөө өгч ажиллалаа. Давхардсан тоогоор уралдаанч 33, туслах уяач 1, эцэг эхийн хараа хяналт сул 1 хүүхдийг илрүүлэн бүртгэсэн ба хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлж ар гэрт нь эргэн нэгтгэсэн.

Илрүүлэлт-2021 арга хэмжээний 4 дүгээр улирлын үйл ажиллагаа зохион байгуулагдаж байна. НГБХЗХГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу 2-р улирлад илэрсэн хараа хяналт сул 1 хүүхдэд эргэн хяналт тавин асран хамгаалагчид зөвлөгөө өгч ажиллав.

Багахангай дүүргийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны 2021 оны анхдугаар хуралдааныг 7 гишүүн буюу 60 хувийн ирцтэйгээр зохион байгуулж, 2020 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан танилцуулан 2021 онд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж гишүүдээс гарсан саналыг тусган батлууллаа.

Бэлгийн хүчирхийллийн хохирогч 7, 14 настай 2 эмэгтэй хүүхдэд хорооны ажлын албаны зүгээс хууль тогтоомжид заасны дагуу хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээг үзүүлэн сурч боловсрох, хөгжих эрхийг ханган давтлага сургалтад хамруулан ажиллаж байна.

Түргэвчилсэн үнэлгээгээр эрсдэлтэй 88 өрхийн 123 иргэн, 299 хүүхдэд ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх талаарх мэдээллийг хүргэн хүүхдээ хараа хяналтгүй орхидог 14 өрхийг хяналтад авсан.

Байгууллагын цахим хаяг болон өөрийн фэйсбүүк хаяг, гишүүнчлэлтэй 7 группээр дамжуулан үер ус, газар хөдлөлтийн гамшиг аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр шторк, постер, мэдээ болон зөвлөмжийг улирал тутам нийтлэн иргэд олон нийтэд түгээн ажиллалаа. Цахим хандалтын тоо 4923 байна.

Мөн ахуйн хүрээний осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 38 мэдээллийг байгууллагын page, гишүүнчлэлтэй 6 группээр дамжуулж нийтэд түгээсэн ба нийт хандалтын тоо 2528 байна.

Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх цахим сургалтыг 4 удаа зохион байгуулж, 235 иргэн хамрагдсан.

Багахангай дүүргийн Цагдаагийн хэлтэстэй хамтран “Ирээдүйгээ хамгаалъя”, “Орон нутгийн зам-хөдөлгөөний соёл” урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээний хүрээнд дүүргийн хариуцсан нутаг дэвсгэр болон А0101 авто зам хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт шалгалт явуулан зөвлөгөө, зөвлөмж, сээрэмжлүүлгийг жолооч, зорчигчдод хүргэсэн.

Зургаа. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны талаарх бодлого, шийдвэрийг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх, архивын тасгаас хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, архивын сан хөмрөгийн хадгалалт, архив, албан хэрэг хөтлөлтийн ажлыг сайжруулах

Засаг даргын Тамгын газарт сүүлийн хагас жилийн байдлаар нийт 1109, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр 2, байгууллагаар бүртгэгдсэн 126, системээр бүртгэгдсэн 981,

хуваарилагдсан 1108, үүнээс хариутай 221, хугацаандаа хаасан 193, хугацаа хэтэрч хаасан 18, судалж байгаа 10, хугацаа дөхсөн 2, хугацаа сунгуулсан 0, шийдвэрлэлтийн хувь 95.73 хувь, хариугүй бичиг 888, хугацаандаа хаасан 861, хугацаа хэтэрч хаасан 11, судалж байгаа 16 шийдвэрлэлтийн хувь 99.37 хувь, нийт ирсэн бичгийн шийдвэрлэлт 96.4 хувьтай байна.

Дүүргийн Архивын 2021 оны ажлын төлөвлөгөөг 6 бүлэг 25 заалттайгаар боловсруулан батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар 104 баримтыг түр хугацаагаар ашиглуулж, 61 лавлагаа хуулбар хувь олгон тоо бүртгэлийн баримт бичгүүдийг бүрэн хөтлөн явуулж байна. Мөн дүүргийн архивт хөмрөг үүсгэгч байгууллагуудын архивын баримтын бүрэлдэхүүн тоо хэмжээ, хадгалалтын талаарх мэдээг "Архивын баримтын нэгдсэн тоо бүртгэлийн систем"-д бүрэн шивж дууссан. Дүүргийн хэмжээнд жилийн эцсийн байдлаар нийт 13923 нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр 4, байгууллагаар бүртгэгдсэн 1579, системээр бүртгэгдсэн 12344, хувиарлагдсан 13923, хариутай 8121, хугацаандаа хаасан 8012, хугацаа хэтэрч хаасан 109, судалж байгаа 163, хугацаа дөхсөн 147, хугацаа сунгуулсан 3, шийдвэрлэлтийн хувь 99,25 хувьтай байна. Дүүргийн хэмжээнд бичгийн шийдвэрлэлтийн дундаж хоног 6,3 байна.

Дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн албан хаагчдад zoom программаар "Тоон гарын үсгийн хэрэглээ, боловсруулалт цэсний ашиглалт сэvdээр цахим сургалт зохион байгуулж 18 албан хаагч хамрагдсан. Мөн Биеийн тамир, спорт хороонд дүүргийн Засаг даргын А/22 дугаар захирамжаар 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг зөвлөн туслах үйл ажиллагааг өөрсдийн чиг үүргийн дагуу үзүүлэн, арга зүйн удирдлагаар хангаж ажиллалаа. Дүүргийн харьяа 26 байгууллагын 28 албан хаагчдад "Баримт бичгийн стандарт 2021" сургалтыг 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулсан. Цахим нөхөн бүрдүүлэлтийн ажлын хүрээнд 2 байгууллага ажлын байранд заавар, зөвлөмж өгөөд байна. Нийтдээ 2 удаагийн сургалтаар 46 албан хаагч хамрагдаж 3 байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байна.

Долоо.Холбогдох хууль тогтоомж, өгсөн үүрэг даалгавар, эрх зүйн шинэтгэлийн бодлогын хэрэгжилт, хууль сахиулах байгууллагуудын харилцан ажиллагааг уялдуулан зохицуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хамтын ажиллагааны үр дүн

Цагдаагийн хэлтэс: Дүүргийн Засаг даргын Тамгын газраас 20,0 сая төгрөгний эд хогшил худалдан авах эрх олгосны дагуу дүүргийн Худалдан авах ажиллагааны албанаас тендэр шалгаруулалт зохион байгуулан, тендерт "Өрнөх Хийморь" ХХК шалгаран 2020 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс 2020 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн хооронд бэлтгэн нийлүүлэх гэрээтэйгээр ажил үйлчилгээг бүрэн хүлээн авсан.

Дүүргийн нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тавигдсан хяналтын камерын засвар үйлчилгээг хийж, 7 ширхэг камер ажиллагаанд оруулсан бөгөөд 9.876.000 төгрөгний төсвийг дүүргийн ГХУСАЗСС-өөс шийдвэрлүүлэн ажилласан. Хэлтсийн байрны гадна орчныг хашаажуулах, цэцэгжүүлэх ажлын талаар төсөв тооцоог гаргаж дүүргийн Засаг даргад танилцуулан ажиллаж байгаа ба барилгын газрыг сунгах талаар танилцуулаад байна.

Найм. Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын орон нутаг дахь байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

"Арт терафи" урлагийн сэтгэл засал ТББ-ын сэтгэл зүйчтэй хамтран дүүргийн хамтарсан багийн гишүүдэд "Сэтгэл зүйн анхан шатны тусlamж үйлчилгээ үзүүлэх нь" сэдэвт сургалтыг цахим онлайн хэлбэрээр зохион байгуулж гишүүдийн үйлчилгээгээ харилцах, зөвлөх ур чадварыг дээшлүүллээ.

Хороодын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах ажлын хүрээнд 3 сургалт, 3 хэлэлцүүлгийг цахимаар зохион байгуулсан ба сургалтад давхардсан тоогоор 61 хүн хамрагдаж мэдлэг, ур чадвараа нэмэгдүүллээ.

Хамтарсан багийн гишүүдэд кейс үйлчилгээ үзүүлэх, чиглэлээр цахим зөвлөгөө 4 удаа, нөхцөл байдлын үнэлгээ хийх, дүгнэлт бичих чиглэлээр ажлын байран дээр 3 удаа очиж арга зүй, зөвлөгөө өгч ажиллалаа.

Хүүхдийн эрхийг зөрчсөн ААНБ, хуулийн этгээд бүртгэгдээгүй ба хүүхдийн эрхийн зөрчил гаргасан 2 иргэнд ЗТХ-ийн дагуу хариуцлага тооцож ажиллав. Мөн хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй 1 иргэнд хууль эрх үйн мэдээлэл өгч, хүүхдийн эрхийг хангах, хүүхэддээ захиран зарцуулах хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хүүхдүүдээ зарцуулах талаар анхааруулж, зөвлөлөө.

Ес. Хүний эрхийн талаарх хууль тогтоомж, хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, иргэд, байгууллагад сурталчлах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулсан ажлын үр дүн

Дүүргийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд жендерийн эрх тэгш байдлыг хангах, жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх асуудлыг тусгав. Мөн 23 ААНБ-ын дарга, эрхлэгчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, байгууллагын дотоод журамд "Жендерийн эрх тэгш байдлыг хангах" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой заалтыг тусгууллаа. "Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 6 зорилт 19 заалт, Дүүргийн "Жендерийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 4 зорилт 23 заалт, "Жендерийн эрх тэгш байдлыг хангах салбар хороо"-ны төлөвлөгөөг 13 заалттайгаар тус тус боловсруулан 23 ААНБ-д хүргүүлэн биелэлтийг ханган ажиллах заавар зөвлөмжийг өгөн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Хөдөлмөрийн мөлжлөг, ажлын байран дахь ялгavarлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үл тэвчих орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран "Жендерийн үндэсний хороо"-ноос төр, төрийн бус байгууллагатай хамтран боловсруулсан "Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй холбоотой гомдлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд хянан шийдвэрлэх талаарх арга зүйн зөвлөмж"-ийг 22 ААНБ-д хүргүүлэн байгууллагын дотоод журамд тусган ажиллах чиглэлийг өгч ажилласнаар 17 ААНБ холбогдох заалтуудыг дотоод журамд нэмж оруулан албан хаагчдад танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 5 ААНБ Ковид-19 цар тахал өвчний өндөржүүлсэн бэлэн байдал буурч, байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдах үед албан хаагчдын хуралдаанаар хэлэлцэн зөвлөмжийг дотоод журамд оруулахаар төлөвлөсөн байна. 2021 онд дүүрэгт идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 18 аж ахуйн нэгж байгууллага 68 иргэнийг ажилд шинээр томилон авсан ба

- Байнгын ажлын байранд 59 (эрэгтэй 29 буюу 57.7 хувь, эмэгтэй 25 буюу 42.3 хувь),
- Түр ажлын байранд 9 (эрэгтэй 1 буюу 11.2 хувь, эмэгтэй 8 буюу 88.8 хувь)

Үүнээс хараад тус дүүрэгт иргэнийг ажилд авахад хүйсээр ялгavarлах хандлага байхгүй байна. Ажилд орсон иргэдээс хүйсээр ялгavarласан тухай зөрчил гомдол гараагүй болно.

Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцооны хувьд Нийслэлийн Багахангай дүүрэг нь нийт 17 төлөөлөгчтэй бөгөөд нийт төлөөлөгчдийн 8 буюу 47.0 хувийг эмэгтэй төлөөлөгчид эзлэж байна.

Мөн Нутгийн захирагааны албан хаагчдын шийдвэр гаргах түвшинд эмэгтэй удирдах албан тушаалтан 50.0 хувийг эзлэж байна. Үүнд: ИТХ-ын дарга, Засаг даргын орлогч, Хэлтсийн 3 дарга, нийт эмэгтэй удирдах албан тушаалтан 5 байна.

2021.03.05-ны өдөр МУИХ, Японы элчин сайдын яамтай хамтран зохион байгуулсан "Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны үнэ цэнэ" онлайн хэлэцүүлэгт дүүргийн 6 удирдах албан тушаалтан оролцож мэдээллээр хангагдav.

2021.03.19-ний өдөр "Монгол эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүтэй байдлын суурь судалгааны зарим тодорхой асуудал" хэлэлцүүлэгт Жендерийн асуудал хариуцсан мэргэжилтэн,

2021.04.14-ний өдөр Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг танилцуулах цахим хэлэлцүүлэг"-т дүүргийн Засаг даргын Эдийн засаг, нийгмийн асуудал хариуцсан орлогч буюу ЖЭТБХ салбар хорооны дарга Б.Болормаа, НХХ-ийн дарга Б.Цогжавхлан, НХХ-ийн ахлах мэргэжилтэн А.Алтантуяа, ТЗУХ-ийн мэргэжилтэн С.Цэнд-Аюуш, ИТХ-ын ажлын албаны дарга М.Давааням нар оролцож мэдээллээр хангагдav.

"Жендерийн үндэсний хорооноос 2021 оны 05 дугаар сарын 27-ноос 29-ний өдрийн хооронд зохион байгуулсан "Сургагч багш бэлтгэх" сургалтад НХХ-ийн ахлах мэргэжилтэн хамрагдаж, сургагч багшаар бэлтгэгдэв.

2021.06.23-ны өдөр жендер хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтад НХХ-ийн ахлах мэргэжилтэн А.Алтантуяа хамрагдav.

2021.06.24-ний өдөр "Эрэгтэй, эмэгтэй малчдын амьдрал ахуй дахь жендерийн дүн шинжилгээ" судалгааны дүng танилцуулах хэлэлцүүлэгт 1, 2 дугаар хорооны нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч нарыг хамруулж мэдээллээр хангав.

2021.10.26-ны өдөр Нийслэлийн Жендерийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтан, жендерийн асуудал хариуцсан албан хаагчдад жендерийн анхан шатны мэдлэг олгох, чадавхжуулах цахим сургалтад дүүргийн Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч, ЖЭТБХСЗ-ийн дарга Б.Болормаа, НХХ-ийн дарга Б.Цогжавхлан, Жендерийн асуудал хариуцсан мэргэжилтэн А.Алтантуяа оролцож мэдээллээр хангагдav.

2021.10.28-ны өдөр "Монголын бичил болон жижиг бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд КОВИД-19 цар тахлын үзүүлж буй нөлөөллийн үнэлгээ" судалгааг танилцуулах цахим хэлэлцүүлэг Жендерийн асуудал хариуцсан мэргэжилтэн А.Алтантуяа оролцож мэдээллээр хангагdav.

2021.11.09-ний өдөр Жендерийн үндэсний хорооноос "ЖЕНДЭР БА ХӨГЖИЛ-2021" үндэсний чуулганд дүүргийн Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч, ЖЭТБХСЗ-ийн дарга Б.Болормаа, ИТХ-ын ажлын албаны дарга М.Давааням нар оролцов.

"Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян"-ы хүрээнд Жендерийн үндэсний хорооноос бэлтгэн, боловсруулсан нөлөөллийн 3 видео шторк, 3 цахим баннер, аяны логог Багахангайн хэвлэл мэдээлэл, 1, 2 дугаар хороо, дүүргийн ИТХ-ын ажлын албаны фэйсбүүк хуудсаар иргэдэд хүргэв. Мөн "Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян"-ы хүрээнд бүхэнд хамаатай" аянд нэгдэн Жендерийн үндэсний хорооноос сургалт авахаар саналаа хүргүүлээд байна.

ХЯНАСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА *L.Санжийжамц* Л.САНЖИЙЖАМЦ

ТАЙЛАН ГАРГАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН *С.Цэнд-Аюуш* С.ЦЭНД-АЮУШ